

БАТЛАВ:



Г.МАГНАЙ / ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /

**ЖИМОБАЙЛ ХХК-ИЙН СҮЛЖЭЭНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭНИЙ
ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ (RIO¹)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Харилцаа холбооны зохицуулах хорооноос (цаашид "Зохицуулах хороо" гэх) 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 33 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам" (цаашид "журам" гэх)-ын 2.3² дахь хэсэгт зааснаар харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (цаашид "нөхцөл" гэх) боловсруулж Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, цахим хуудсандаа байршуулах үүрэгтэй.
- 1.2 Энэхүү баримт бичгийн зорилго нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгч нь бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд харилцан холбогдох үйл ажиллагааг нээлттэй болгох, харилцан холболт хийх эрхийг баталгаажуулах, талуудын техник технологийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх зэргээр энэ нөхцөлийн 1.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оршино.
- 1.3 Энэхүү нөхцөл нь Жимобайл ХХК (цаашид "Жимобайл" гэх) болон тусгай зөвшөөрөл бүхий сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлт гаргагч (цаашид "Хүсэлт гаргагч" гэх) нарын (хамтад нь "Талууд" гэх) сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, зааглах цэгийн байршил, гэрээ байгуулах, төлбөр тооцоо, орлого хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.4 Энэхүү баримт бичиг нь Монгол улсын "Харилцаа холбооны тухай" хууль, Зохицуулах хорооноос баталсан "Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам" болон бусад холбогдох журам, зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрүүдтэй нийцтэй байна.
- 1.5 Сүлжээ хоорондын харилцан холболт нь Талууд өөрсдийн хэрэглэгчдийн харилцаа холбооны хэрэгцээг (харилцан яриа хийх, мессеж бичих) хангах шаардлагын хүрээнд хийгдэнэ.
- 1.6 Жимобайл нь сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ байгуулахдаа Монгол улсын цахилгаан холбооны дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Зохицуулах хорооноос хуваарилсан дугаарыг ашиглан Монгол Улсын Үндэсний стандарт, зөвлөмж, журам, зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрүүдийг мөрдлөг болгон ялгаваргүй, ижил тэгш нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа

үйлдэл гаргахгүй байх, нээлттэй сүлжээний стандартыг хангах зэрэг үндсэн зарчмуудыг баримтлан ажиллана.

- 1.7. Энэхүү нөхцөл болон "Сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ"-нд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсын Харилцаа холбооны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 1.8. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчлэгчтэй сүлжээнд харилцан холболт хийх гэрээ байгуулахдаа хууль, журам болон энэхүү нөхцөлд заасан хэм хэмжээг мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЪЁО

- 2.1 Хүсэлт гаргагч гэж Жимобайлын үүрэн холбооны сүлжээнд харилцан холбогдох хүсэлтэй харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хэлнэ.
- 2.2 Телефон ярианы үйлчилгээ гэдэгт "Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Телефон ярианы үйлчилгээнд)"-ын 1.3³-д заасан суурин болон үүрэн холбооны бүх төрлийн телефон ярианы үйлчилгээг ойлгоно.
- 2.3 Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1-15.16.3 , 15.16.5-15.16.7⁴-д заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг ойлгоно.
- 2.4 Зааглах цэг гэж Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг ойлгоно.

³ Reference Interconnection Offer

² Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (RIO) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж, өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд:

2.3.1 Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага;

2.3.2 Зааглах цэгийн байршил;

2.3.3 Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

2.3.4 Гэрээний загвар

³Телефон ярианы үйлчилгээ гэдэгт Монгол улсын нутаг дэвсгэрт болон Монгол улсаас бусад улс оронд цахилгаан холбооны сүлжээ ашиглан Монгол улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө (цаашид "Дугаарлалтын төлөвлөгөө" гэх)-ний дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос хуваарилсан дугаарыг ашиглан хэрэглэгчид үзүүлэх суурин болон үүрэн холбооны бүх төрлийн телефон ярианы үйлчилгээг ойлгоно.

⁴15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

15.16.2. харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх

15.16.3. контентын үйлчилгээ эрхлэх

15.16.5. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;

15.16.6. радио, телевизийн үйлчилгээ;

15.16.7. олон суваг дамжуулах үйлчилгээ.

**ГУРАВ. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ,
ГОРИМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

- 3.1. Хүсэлт гаргагчийн техник хангамж, тоног төхөөрөмж нь Олон улсын стандартын шаардлагыг хангасан байх ба харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхтэй холбоотой тоног төхөөрөмжийн угсралт болон кабель шугамын суурилуулалтыг хийж гүйцэтгэхдээ энэ талаар батлагдан гарсан Үндэсний стандартыг мөрдөн ажиллана.
- 3.2. Хүсэлт гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага хяналтын нэгдсэн системтэй байх ба техник тоног төхөөрөмжид хяналт, хэмжилт хийх хэмжүүрийн багаж хэрэгсэл, программ хангамжаар хангагдсан байна.
- 3.3. Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан холболтын байгууламжтай байна. Үүнд:
 - 3.3.1 Сүлжээ хоорондын дохиолол нь CCS7 эсвэл SIP байх ба өргөн зурвасын дохиоллын бусад протоколыг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 3.3.2 Сүлжээний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангасан байх;
 - 3.3.3 Ярианы болон бусад холбогдох протоколууд ба кодыг дэмжих, тэдгээрийн хувиргалт, шилжилтийг хийдэг байх;
 - 3.3.4 Ярианы төлбөрийг секундын нарийвчлалтай тооцох боломжтой байх;
 - 3.3.5 Бусад сүлжээтэй ITU-T стандартуудын дагуу холбох шугамаар холбогдох боломжтой байх;
 - 3.3.6 Дотоод болон олон улсын мессежний хувьд SMPP 3.4 протоколыг дэмждэг байх
- 3.4. Хүсэлт гаргагч нь ярианы үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дээрх стандартыг хангасан холболтын байгууламж (soft switch, gateway, router) төлбөр тооцооны систем (billing system) зай тэжээлийн төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын систем (network management system)-ийг ашиглана.
- 3.5. Хүсэлт гаргагч нь өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас сүлжээ хооронд харилцан холболт хийсэн харилцаа холбооны үйлчлэгчид үүссэн хохирлыг хариуцна.
- 3.6. Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах (CLI-Call line identification) үүрэгтэй. Энэ нь улс хооронд болон улс доторх ярианд ижил хамаарна.
- 3.7. Хүсэлт гаргагчаас ирүүлсэн харилцан холболт хийх хүсэлт дээр хийгдсэн ачааллын таамаглал нь Жимобайлын тухайн үеийн багтаамжаас давах тохиолдолд харилцан холболтыг хийж гүйцэтгэх хугацааг*, нөөц бэлэн болох хугацаатай уялдуулж, талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

- 3.8. Сүлжээ хооронд харилцан холболт хийх горимд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлийг аль нэг тал нь санаачлан хийх бол 3 сараас доошгүй хугацааны өмнө өөрчлөлт хийх талаарх мэдээлэл, үндэслэл, шаардагдах техникийн нөхцөлийг бусад харилцаа холбооны үйлчлэгчдэд мэдэгдэн тохиролцох ба энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэнэ.
- 3.9. Харилцаа холбооны үйлчлэгч нь энэхүү нөхцөлд тусгагдсан сүлжээ хооронд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлагаас өөр нөхцөлийг телефон ярианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд тавихыг хориглоно.
- 3.10. Хэрэв Хүсэлт гаргагч нь энэхүү нөхцөлийн 3 дугаар зүйлд тусгагдсан техникийн нөхцөл шаардлагыг хангаагүй бол Жимобайл нь харилцан холболт хийхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд ажлын 10 хоногийн дотор хариуг хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

- 4.1. Жимобайл нь өөрийн сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг болон сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил, холболтын төхөөрөмжийн жагсаалтыг энэхүү нөхцөлийн Хүснэгт 1-т заасан байх ба зааглах цэгийн байршлыг Зохицуулах хороо эцэслэн баталгаажуулна.
- 4.2. Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн Хавсралт 1-т заасан гэрээний загварт Хүсэлт гаргагчтай харилцан тохиролцсоноор нарийвчлан, тодорхой оруулна.
- 4.3. Хүсэлт гаргагч нь Зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 4.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоохоор бол Жимобайл нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн боломж байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлтийг Зохицуулах хороонд албан бичгээр ирүүлж, шийдвэрлүүлнэ. Харин Жимобайл нь зааглах цэгийн байршлыг энэхүү нөхцөлийн 4.1 дэх хэсэгт зааснаас өөр байрлалд тогтоох хүсэлттэй бол Зохицуулах хороонд үндэслэл, техникийн нөхцөлийн боломжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлж, тухай бүр шийдвэрлүүлнэ.
- 4.4. Хүсэлт гаргагч нь Харилцаа холбооны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1⁵ дэх хэсэгт заасны дагуу харилцаа холбооны үйлчлэгчийн сүлжээ хооронд харилцан холболт хийх зааглах цэг хүртэл шаардагдах хөрөнгө оруулалтын хариуцна.
- 4.5. Талууд сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

⁵22.1 Тусгай хэрэглээний холбооны сүлжээ эзэмшигч, дотоодын хэрэглээний сүлжээ бүхий болон шинээр сүлжээ байгуулах этгээд бусдын өмчлөлийн сүлжээнд холболт хийхдээ сүлжээ хоорондын зааглах цэгт тавигдах нэмэгдэл шулам, тэнэг төхөөрөмжийг хариуцна.


ХҮСНЭГТ 1. ЗААГЛАХ ЦЭГ, ХОЛБОЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Жимобайл
Холболтын байгууламжийн төрөл, марк	ZTE ZXC10 MSCE
Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк	SDH-STM 16
Холбох шугамын төрөл, марк, багтаамж	G703
Интерфэйсийн төрөл	Optic fiber 120 Ohm

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил
Зааглах цэг 1-ийн байршил	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн төв байр, 2-р давхар, техникийн өрөө
Зааглах цэг 2-ын байршил	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн төв байр, В1 давхар шахтын өрөө
Тоног төхөөрөмж	ODF Optic fiber, DDF 120 Ohm



ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Түрээсийн шугам ашиглахаас бусад тохиолдолд зааглах цэгээс 2 тийш талууд өөрсдийн шугам, сүлжээний ашиглалт үйлчилгээ, гэмтэл засвар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 5.2. Талууд өөрийн сүлжээ хооронд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх, гэмтэл саатлын үед ажиллах хугацаа, горимыг хуанлийн 7 хоногийн өмнө и-мэйл, албан тоот зэрэг бичгээр урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 5.3. Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг гэрээний Хавсралт 5-д тусгана.
- 5.4. Талууд үйлчилгээний чанарын шаардлагыг хангах үүднээс тус тусын хариуцаж буй зааглах цэг хүртэлх сүлжээ, дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд энэхүү нөхцөлийн Хавсралт 1-т заасан гэрээний загварт дангаар эсвэл тусгай нөхцөл тогтоож болно.

ЗУРГАА. СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ

ТӨЛБӨР ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

- 6.1. Талууд нь сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 6.2. Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна.
- 6.3. Зохицуулах хорооноос харилцан холболтын төлбөрт зохицуулалт хийсэн тохиолдолд гэрээнд тусган мөрдөж ажиллана.

ДОЛОО. ГЭРЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 7.1. Жимобайл нь Хүсэлт гаргагчтай сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ байгуулахдаа доорх дарааллын дагуу ажиллана.

Д/д	Үйл ажиллагаа	Үйл ажиллагаанд зарцуулах хугацаа
1	Сүлжээ хоорондын харилцан холболт хийх хүсэлт гаргагч нь хүсэлтээ албан бичгээр Жимобайлд ирүүлнэ. Хүсэлтэд дараах баримтыг заавал хавсаргана. Үүнд: 1. Компанийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар,	

	дугаарлалтын гэрээ, холбогдох шийдвэр 3. Холболтын байгууламжийн төрөл, холболтын санал, зааглах цэгийн байршил, холболт хийх гэж буй төхөөрөмжийн талаарх мэдээлэл 4. Техникийн болон гэрээ хариуцсан ажилтнуудын холбоо барих мэдээлэл 5. Энэхүү нөхцөлийн 3-р зүйлд тусгасан гэрээний нөхцөлийг хангах талаар бусад мэдээлэл зэрэг болно.	Албан бичгийн хамт
2	Жимобайл нь хүлээж авсан материалын иж бүрдэл бүрэн эсэх, хүчин төгөлдөр, шаардлага хангах эсэхийг нягтлан шалгана. Хэрэв баримт, мэдээлэл дутуу ирсэн тохиолдолд хүсэлт гаргагчид утсаар эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.	Хүсэлт авснаас хойш ажлын 5 хоногт
3	Энэхүү нөхцөлд дурдагдсан технологийн стандарт горим, нөхцөл шаардлагыг бүрэн хангасан бол харилцан холболт хийх техникийн боломжийг судалж техникийн нөхцөлийг гаргаж хүсэлт гаргагчид цахим шуудангаар илгээнэ. Энэ мэдэгдлийг техникийн нөхцөл гэж ойлгоно.	Ажлын 10 хоногт
4	Харилцан холболтын гэрээний төслийг бэлтгэн Хүсэлт гаргагчийн холбогдох хаяг руу илгээнэ.	Техникийн нөхцөл гарснаас хойш ажлын 5 хоногт
5	Гэрээний нөхцөлийг хүсэлт гаргагчтай эцэслэн тохирно.	Гэрээний төсөл илгээснээс хойш хуанлийн 30 хоног
6	Гэрээний нөхцөл тохирч гэрээг 3 эх хувь баталж, тал тус бүр нэгийг, ХХЗХ-нд нэг эх хувийг хүргүүлнэ.	Гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээ болон түүний хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ.
7	Гэрээ батлагдаж техникийн нөхцөлийг тохирсны дараа доорх дарааллаар хүсэлт гаргагчтай хамтран ажиллана. 1. харилцан холболтыг хийж гүйцэтгэнэ 2. холбогдох тестүүдийг хийнэ 3. холболт болон төстийн протокол хөтөлж хоёр тал гарын үсгээр баталгаажуулж тус бүрийг гэрээнд хавсаргана.	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 30 хоногт

7.2. Жимобайл нь техникийн нөхцөл олгох боломжийг судлах зорилгоор энэхүү нөхцөлийн 7.1 дэх хэсэгт зааснаас гадна байгууллагын нууцад хамаарахгүй нэмэлт мэдээлэл шаардаж болно.

7.3. Хүсэлт гаргагч нь хүсэлтээ журмын 3.17^б дэх хэсэгт заасан хэлбэрээр гаргах

бөгөөд Жимобайл нь уг хэлбэрээс бусад маягаар ирүүлсэн аливаа хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй.

- 7.4. Хүсэлт гаргагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөр шүүж, түрүүлж ирснийг нь эхэнд шийдвэрлэх зарчим баримтална.
- 7.5. Хэрэв Жимобайл нь техникийн нөхцөл гаргах боломжгүй бол хүсэлт гаргагч талд тухайн нөхцөлийг олгох боломжгүй үндэслэл болон бүрдүүлэх боломжтой болох хугацааг тодорхой дурдсан холбогдох тайлбарыг хүргүүлэх ба хувийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 7.6. Талууд техникийн нөхцөл авснаас 3 сарын дотор холболтоо хийж эхлээгүй бол тухайн техникийн нөхцөл хүчингүй болно.
- 7.7. Хүсэлт гаргагчийн тусгай зөвшөөрөл хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд Жимобайлаас олгосон техникийн нөхцөл хүчингүй болно.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

- 8.1. Жимобайл нь Харилцаа холбооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1⁷ дэх хэсэгт зааснаар Хүсэлт гаргагчийг өөрийн сүлжээндээ холбохдоо гэрээ байгуулна.
- 8.2. Энэхүү нөхцөлийн 8.1 дэх хэсэгт заасан гэрээг сүлжээнд харилцан холболт хийх болон сүлжээний ашиглалт үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулна. Сүлжээний ашиглалт, үйлчилгээг зохицуулахаар тусдаа гэрээ байгуулахыг хориглоно.
- 8.3. Талууд сүлжээний ашиглалт үйлчилгээг журмын 7.2⁸ дахь хэсэгт зааснаас өөрөөр хариуцах тохиолдолд гэрээндээ энэ талаар тодорхой тусгана.
- 8.4. Сүлжээнд холбогдох харилцан холболтын гэрээний төслийг боловсруулахдаа энэхүү нөхцөлийн 3 дугаар зүйлд заасан сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим нөхцөл шаардлагыг салшгүй хэсэг болгоно.
- 8.5. Энэхүү нөхцөлийн 8.4 дахь хэсэгт заасан гэрээний салшгүй хэсэгт сүлжээнд харилцан холболт хийж буй Хүсэлт гаргагчийн хүсэлтээр хууль болон Зохицуулах хорооноос баталсан журам, нөхцөл шаардлага, шийдвэрээр хязгаарласан асуудлаас бусад асуудлаар харилцан тохиролцон өөрчлөлт оруулах боломжтой байна. Бусад тохиолдолд энэхүү нөхцөлийн 3 дугаар зүйлд зааснаас өөрөөр гэрээнд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 8.6. Хүсэлт гаргагчийн техникийн нөхцөл нь энэхүү нөхцөлийн 7.7 дахь хэсэгт зааснаар хүчингүй болсон тохиолдолд сүлжээний харилцан холболтыг салгах арга хэмжээ авч, Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх бөгөөд сүлжээнд харилцан холбогдох гэрээндээ уг нөхцөлийг хэрэгжүүлэх заалтыг заавал тусгана.
- 8.7. Журмын 7.3 дахь хэсэгт зааснаар *сүлжээнд харилцан холболт хийх түүнтэй холбоотой аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд тохиролцон гэрээнд тусгана.

ЕС. ГОМДОЛ ГАРГАХ

9.1 Энэхүү нөхцөлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар журмын 10.1⁹ дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

-
6. Харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх хүсэлтийг харилцаа холбооны үйлчлэгчид бичгээр гаргана.
 7. Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр зохицуулна.
 8. Талууд сүлжээ хооронд харилцан холболтын зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.
 9. Харилцан холболт хийх гэрээний нөхцөл, зааглах цэг, төлбөр, журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг зорих бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 31.2 дахь заалтын дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

Харилцан холболт хийх гэрээний
ерөнхий нөхцөл (RIO)-ийн Хавсралт 1



ЖИМОБАЙЛ ХХК БОЛОН -

-ИЙН

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

Оны дугаар сарын -ний өдөр,
Улаанбаатар хот

№.....

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ нь Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомж, Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос харилцан холболтын талаар баталсан холбогдох дүрэм журмуудыг үндэслэн

Нэг талаас: ---- /цаашид "----" гэх/, түүнийг төлөөлж Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д заасныг үндэслэн Ерөнхий захирал ---,

Нөгөө талаас: Жимобайл ХХК /цаашид "Жимобайл" гэх/, түүнийг төлөөлж Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д заасныг үндэслэн Гүйцэтгэх захирал ---- /хамтад нь "Талууд", зарим тохиолдолд дангаар нь "Тал" гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Талууд өөрийн сүлжээний хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилгоор нөгөө талын сүлжээтэй харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 ---- /цаашид --- гэх/-ийн харилцан холболтыг өөрийн сүлжээгээр дамжуулан хийж болох ба /цаашид транзит гэх/ энэ тохиолдолд ---- болон Жимобайлтай байгуулсан харилцан холболтын гэрээг үндэслэл болгоно.
- 1.3 Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.4 Талууд ХХЗХ-ноос баталж гаргасан "Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам"-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.5 **Энэхүү гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:**
 - 1.Үндсэн хэсэг
 - Ерөнхий зүйл
 - Талуудын эрх үүрэг
 - Техникийн нөхцөл
 - Ашиглалт үйлчилгээ

- Төлбөр тооцоо
- Нууц хадгалах
- Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх тухай
- Хариуцлага
- Маргаан шийдвэрлэх
- Гэрээний үйлчлэх хугацаа
- Давагдашгүй хүчин зүйл
- Бусад

2. Хавсралт 1. Техникийн үзүүлэлт, Зааглах цэгийн байршил

3. Хавсралт 2. Харилцан холболтын зураглал

4. Хавсралт 3. Талуудын сүлжээний дугаарлалт

5. Хавсралт 4. Харилцан холболтын үйлчилгээний үнэ, тооцоо нийлэх маягт

6. Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн хаяг, холбоо барих арга хэрэгсэл

1.6 Энэхүү гэрээний хүрээнд талууд дор дурдсан харилцан холболтын үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- 1.6.1 Дотоод дуудлага хүлээн авах;
- 1.6.2 Дотоод гарах дуудлага хийх;
- 1.6.3 Улс хоорондын дуудлага хүлээн авах;
- 1.6.4 Улс хоорондын гарах дуудлага хийх.
- 1.6.5 Дотоод мессеж бичих
- 1.6.6 Дотоод мессеж хүлээн авах

1.7 Энэхүү гэрээний хүрээнд талууд дор дурдсан транзит үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- 1.7.1 Дотоодын орох дуудлага дамжуулах;
- 1.7.2 Дотоодын гарах дуудлага дамжуулах;
- 1.7.3 Улс хоорондын орох дуудлага дамжуулах;
- 1.7.4 Улс хоорондын гарах дуудлага дамжуулах
- 1.7.5 Дотоод мессеж бичих
- 1.7.6 Дотоод мессеж хүлээж авах.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1 Талууд дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:

- 2.1.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
- 2.1.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах, гэрээнээс татгалзах, цуцлах, дуусгавар болгох тухай санал гаргах;

- 2.1.3 Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
 - 2.1.4 Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 8 дугаар зүйлд заасан хариуцлагын механизмыг шат дараатайгаар хэрэглэх,;
 - 2.1.5 Үйлчилгээний төлбөр, алданги нэхэмжлэн авах;
 - 2.1.6 Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах;
 - 2.1.7 Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулан авах
 - 2.1.8 Гэрээний явцад харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах эрхтэй.
- 2.2 Талууд харилцан холболтын гэрээнд дор дурдсан үүргийг хүлээнэ.Үүнд:**
- 2.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
 - 2.2.2 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх;
 - 2.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талынхаа бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 2.2.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх;
 - 2.2.5 Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх;
 - 2.2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол ХХЗХ-нд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний болон гэрээнд оролцогч талын хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх.
 - 2.2.7 ХХЗХ болон салбарын эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, нөхцөл шаардлага, тогтоол шийдвэрийг чанд мөрдөж ажиллах.

Гурав. Техникийн нөхцөл

Энэ хэсэгт Талуудын сүлжээ хоорондын харилцан холболт хийх техникийн нөхцөл, сүлжээ төлөвлөлт, зааглах цэг, дугаарлалт, ачаалал зэргийг тусгана.

3.1 Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт

- 3.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байх ба өөрчлөлтүүдийг тухай бүр тусгана.
- 3.1.2 Сүлжээ хоорондын дохиолол нь CCS7 эсвэл SIP байх ба өргөн зурвасын дохиоллын бусад протоколыг ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.1.3 Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.

3.2 Зааглах цэг

- 3.2.1 Сүлжээний зааглах цэгүүдийн байршил Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 3.2.2 Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.

- 3.2.3 Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
 - 3.2.4 Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.
- 3.3 Сүлжээний ачаалал**
- 3.3.1 Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
 - 3.3.2 Нэгж шугамд ногдох ачааллын хэмжээг 0.65 Эрлангаас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
 - 3.3.3 Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талуудын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг 3 сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.4 Дугаарлалт**
- 3.4.1 Талуудын сүлжээний дугаарлалт нь ХХЗХ-оос олгогдсон дугаарлалтын хүрээнд Хавсралт 3-д заасны дагуу байна.
 - 3.4.2 Аль нэг тал хууль тогтоомжийн хүрээнд сүлжээний дугаар шинээр үүсгэх тохиолдолд нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж баталсан өдрөөс хойш ажлын 5 (тав) хоногт багтаан сүлжээнд үүсгэнэ.
 - 3.4.3 Талууд нөгөө талын сүлжээнд яриа төгсгөхдөө дуудлага эхлүүлсэн хэрэглэгчийн дугаарыг дуудлага хүлээн авч буй хэрэглэгч дээр харуулах үүрэгтэй. Энэ нь улс хооронд болон улс доторх ярианд ижил хамаарна.

Дөрөв. Ашиглалт үйлчилгээ

- 4.1 Түрээсийн шугам ашиглахаас бусад тохиолдолд зааглах цэгээс 2 тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл засвар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.2 Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг хуанлийн 7 хоногийн өмнө албан тоот болон цахим шуудангийн аль алианаар нь урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 4.3 Талууд Харилцан холболтын ярианы өгөгдлүүд нь талуудын төлбөр тооцооны системд зөв ажиллаж байгаа талаар жил бүрийн эхний улиралд багтаан тест хийн баталгаажуулж протокол үйлдэж байна.
- 4.4 Аль нэг Тал нь нөгөө Талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан Тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нэн даруй нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар Талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 4.5 Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг Талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус гэмт хэргийн шинжтэй халдлага, дайралт (attack, fraud) зэрэгт өртөх тохиолдолд тухайн тал нь нөгөө талд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.

- 4.6 Талууд өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас харилцан холболт хийсэн болон холбогдсон тохиолдолд дээрх шаардлагыг хангаагүй Тал нь үүссэн хохирлыг хариуцна.
- 4.7 Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг Хавсралт 5-д тусгана.

Тав. Төлбөр тооцоо

- 5.1. Талууд энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.6 болон 1.7 -д заасан үйлчилгээнүүдийн харилцан холболтын төлбөрийг Хавсралт 4-т зааснаар сар бүр төлнө.
- 5.2. ---- болон Жимобайлын харилцан холболтын төлбөр тооцоо нь тэдгээрийн хооронд байгуулагдсан харилцан холболтын гэрээгээр зохицуулагдана.
- 5.3. Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол үйлдэж гэрээнд хавсаргана. Талууд нэгэнт холбогдсон, гэрээний хугацааг сунгаж буй тохиолдолд энэхүү заалт хамаарахгүй.
- 5.4. Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцөлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг 1 секундын алхамтайгаар тооцно.
- 5.5. Талуудын төлбөр тооцоо хариуцсан ажилтнууд харилцан холболт хийгдсэн ачааллын өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 6 хоногт багтаан электрон хэлбэрээр харилцан солилцож, хуанлийн 8 хоногт багтаан тооцоог Хавсралт 4-т заасан үнэ тариф болон тооцоо нийлэх маягтын дагуу цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.6. Хэрэв талуудын ачааллын өгөгдлийн зөрүү нь аль бага талын өгөгдлийн $\pm 1\%$ /хувь/-аас хэтрэхгүй бол Талуудын өгөгдлийн дунджаар, аль бага талын өгөгдлийн $\pm 1\%$ /хувь/-аас хэтэрсэн нөхцөлд тухайн тайлант сарын тооцоог аль бага талын өгөгдлийн дүнгээр 5.5-д заасан хугацаанд багтаан нийлж зөрүүг ажлын хэсэг байгуулан дараагийн тайлант сарын төлбөр тооцоо нийлэхээс өмнө тодорхойлж дараа сарын төлбөр тооцоонд тусгана.
- 5.7. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог 5.5 заасан хугацаанаас хойш ажлын 3 хоногт багтаан нийлж илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба нэхэмжлэхийн дагуу төлбөр хариуцагч тал нь тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 15 хоногийн дотор харилцан холболтын төлбөрийн зөрүүг түүнд ноогдох НӨАТ-ын хамт төлнө.
- 5.8. Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 5.9. Талууд харилцан холболтын ачааллын өгөгдлийн зөрүүг Хавсралт 4-2-т заасан тооцоо нийлэх маягтын дагуу чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 5.10. Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.11. Талуудын сүлжээнд төгсөж байгаа ачаалал нь Хавсралт 3-т дурдсанаас өөр дугаарлалтаар төгссөн тохиолдолд Талуудын холбох шугамаар орж ирсэн л бол тухайн ачааллыг Талуудын үүсгэсэн ачаалал гэж тооцон харилцан холболтын төлбөрийн тооцоог нийлнэ.
- 5.12. Талууд нь тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн 5%-ийг тус тусын Талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.13. Аль нэг Тал өөрийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө нөгөө Талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

- 5.14. Энэ гэрээний 5.7-д заасны дагуу илүү төлөлттэй талдаа харилцан холболтын төлбөрийн нэхэмжлэхийг тухайн цаг хугацаанд гаргаагүй нь төлбөрийг шаардах эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

Зургаа. Нууц хадгалах

- 6.1 Талууд гэрээ байгуулах болон хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан нөгөө талын бизнесийн болон хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээлэл баримт (дотоод зохион байгуулалт, техникийн шийдэл, хамгаалалт, аюулгүй байдал гэх мэт)-ийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхол, эсвэл түүний эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар, бичгээр болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 6.2 Талууд энэхүү гэрээний хүрээнд олж авсан мэдээллийг боловсруулах, ашиглах, дамжуулах бол зөвхөн нөгөө талаас зөвшөөрөл авах, холбогдох хуулийн нийцлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд ийнхүү хангаагүйгээс үүсэх аливаа эрсдэлийг өөрөө бүрэн хариуцна.
- 6.3 Энэхүү гэрээний 6.1, 6.2-д заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд буруутай тал түүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.
- 6.4 Төрийн эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд 6 зүйлд заасан зөвшөөрлийг авах шаардлагагүй.

Долоо. Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх

- 7.1. Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор хүсэлт гаргасан талд гаргаж өгнө. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 7.2. Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрт нь аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 7.3. Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө талын сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө талдаа тухай бүр ажлын 10 хоногийн өмнө мэдэгдэх ба хүлээж авсан Тал ажлын цар хэмжээнээс хамааран гүйцэтгэх хугацааг тохирон хэрэгжүүлнэ. Жич: Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 7.4. Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

Найм. Хариуцлага

- 8.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.2. Аль нэг тал энэ гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 8.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа зохих ёсоор биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг

хангах дор дурдсан аргыг шат дараатайгаар эсвэл шууд хэрэглэх эрхтэй байна. Үүнд:

- 8.3.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлэх.
- 8.3.2. Энэхүү гэрээний 8.4 -т заасан нөхцөлийн дагуу алданги тооцох;
- 8.3.3. Аль нэг тал нь харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн тохиолдолд 2.2.6-р заалтыг хэрэгжүүлэн харилцан холболтын хязгаарлалт, салгалтыг хийх;
- 8.4. Алдангийг дор дурдсан нөхцөлд тооцно. Үүнд:
 - 8.4.1. Аль нэг тал энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн бол;
 - 8.4.2. Аль нэг Талын аливаа алдаа эсвэл буруутай үйлдлээс шалтгаалж харилцан холболтын тооцоог энэхүү гэрээний 5.5-д заасан хугацаанд багтаан нийлээгүйн улмаас 5.7-т заасны дагуу төлбөр төлөх хугацаа хойшилсон бол;
 - 8.4.3. Аль нэг тал энэ гэрээ болон хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцан холболтын тооцоог нийлээгүй, нийлэхийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас гэрээний 5 дугаар зүйлийн 5.7-д заасан хугацаа өнгөрсөн бол.
- 8.5. Алданги нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0,3 хувь байна.
- 8.6. Талууд энэхүү гэрээний 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг шат дараатайгаар хэрэглэж эхэлснээр буруутай тал 30 хоногийн дотор гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 8.7. Энэхүү гэрээний 8.3-т заасан арга хэмжээг хүлээсэн нь талуудыг гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхгүй байх болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүй.
- 8.8. Учирсан хохирол гэдэгт аль нэг талаас гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талаас гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, гэм буруутай тал гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн бол нөгөө талд учрахгүй байсан зарлага зэргийг тооцно.

9. Ес. Маргаан шийдвэрлэх

- 9.1. Энэ гэрээтэй холбогдон үүсэж болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 9.2. Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд аль болох хүлээж авахыг эрмэлзэх бөгөөд хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй эсвэл ХХЗХ хуульд заасан хугацаанд шалгаж хариу өгөөгүй бол Талууд шүүхэд хандах эрхтэй.

10. Арав. Гэрээний үйлчлэх хугацаа

- 10.1. Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар гэрээ --- оны ---р сарын ---ний өдрөөс эхлэн --- жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 10.2. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд энэхүү гэрээ нь ижил нөхцөлөөр нэг жилийн сунгагдана.
- 10.3. Талууд 8.6-д зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээг харилцан тохиролцож цуцалж болох ба энэхүү гэрээнд заасан нөхцөлөөс бусад тохиолдолд гэрээг аль

нэг тал дангаараа цуцлахыг хориглоно. Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ нөгөө Талдаа 2 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө Тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.

- 10.4. Гэрээний хугацаа дуусгавар болсноор мөн гэрээ цуцлагдсанаар гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой шаардах эрхээс бусад талуудад олгогдсон эрх, үүрэг мөн адил дуусгавар болно.

11. Арван нэг. Давагдашгүй хүчин зүйл

- 11.1. Давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 11.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 11.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 11.4. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 11.5. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

12. Арван хоёр. Бусад

- 12.1. Талууд харилцан хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй.
- 12.2. Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 12.3. Энэхүү гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 12.4. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гэрээг хавсралтуудын хамт ХХЗХ-д хүргүүлнэ. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг тухай бүр ХХЗХ-нд тухай бүр хүргүүлж байна.
- 12.5. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд 20.....-оны-р сарын-ны өдөр байгуулсан тоот Сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ болон түүний нэмэлт гэрээнүүдийг дуусгавар болсонд тооцно.
- 12.6. Гэрээний 12.5-ын дагуу өмнөх гэрээг цуцалсан нь уг гэрээний төлбөрийн шаардлага гаргах эрхийг хөндөхгүй буюу дуусгавар болгохгүй.
- 12.7. Талуудын Хувь нийлүүлэгчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, хувьцааны өмчлөл зэрэг өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээний 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

- 12.8. Аль нэг тал энэ Гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 12.9. Талууд энэхүү гэрээ байгуулагдахаас өмнөх төлбөр тооцоог "тооцоо нийлэх акт"-ыг үндэслэн энэ гэрээний Хавсралт 4-т заасан үнэ тарифын дагуу бүрэн төлж барагдуулна.

Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:

Хаяг:

Хаяг:

Бүртгэлийн гэрчилгээ:

Бүртгэлийн гэрчилгээ:

Регистрийн дугаар:

Регистрийн дугаар:

Утас :

Утас : 98106000

Факс:

Факс:

Гэрээ байгуулсан:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг



талууд-ын

Сүлжээ хоорондын харилцан холболтын

..... тоот гэрээний Хавсралт 1

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	-	Жимобайл
Холболтын байгууламжийн төрөл, марк		
Дамжуулах /нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк		
Холбох шугамын төрөл, марк, багтаамж		
Интерфейсийн төрөл		

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэг	Байршил
Зааглах цэг 1-ийн байршил	
Зааглах цэг 2-ийн байршил	
Тоног төхөөрөмж	

Хавсралт баталсан:

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг

Сүлжээ хоорондын харилцан холболтын

..... тоот гэрээний Хавсралт 2



СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

Талуудын сүлжээний топологи, зааглах цэгийн байрлал зургаар

Хавсралт баталсан:

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг



Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний Хавсралт 3

ТАЛУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ
----- ТЕЛЕФОН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
----- холбооны дугаарлалт	
"---"-н Улс хоорондын гарцын дугаарлалт	

ЖИМОБАЙЛЫН ТЕЛЕФОН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
"Жимобайл"-н Улс хоорондын гарцын дугаарлалт	

Хавсралт баталсан:

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг

Сүлжээ хоорондын харилцан холболтын

тоот гэрээний

Хавсралт 4-1

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

Хотын хоорондын ярианы харилцан холболт

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	---	Жимобайлд
Жимобайл-аас руу	Үүрэн	Үүрэн	ЖМ	ХХЗХ-с баталсан ХХ-ын орлого хуваарилах зарчим, тогтоолын дагуу	
-аас Жимобайл руу	Үүрэн	Үүрэн			

Улс хоорондын ярианы харилцан холболт

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф		Жимобайлд
-аас Жимобайл руу	Монгол /009/	Гадаад		ХХЗХ-с баталсан ХХ-ын орлого хуваарилах зарчим, тогтоолын дагуу	
Жимобайл-аас руу	Гадаад /009/	Монгол			

ЖМ – “Жимобайл”-ийн тухайн үйлчилгээний тариф

– “ ”-ийн тухайн үйлчилгээний тариф

УХ1 – “Жимобайл”-ийн улс хоорондын 009 гарцын тариф

Хот хоорондын мессеж үйлчилгээний харилцан холболтын тариф

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф		Жимобайлд
Жимобайл-аас руу	Үүрэн	Үүрэн	ЖМ	ХХЗХ-с баталсан ХХ-ын орлого хуваарилах зарчим, тогтоолын дагуу	
-аас Жимобайл руу	Үүрэн	Үүрэн			

ЖМ – “Жимобайл”-ийн тухайн үйлчилгээний тариф

– “ ”-ийн тухайн үйлчилгээний тариф

Хавсралт баталсан:

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг



талууд-ын

Сүлжээ хоорондын харилцан холболтын

..... тоот гэрээний Хавсралт 4-2

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТООЦОО НИЙЛЭХ МАЯГТ

		Тооцоонд хамрагдах хугацаа: 20..... он сар		
Жимобайлаас->.....руу	тариф	дуудлага	хугацаа /мин/	Төлбөр
Яриа				
Жимобайлаас _____ Үүрэн-руу				
Жимобайлаас _____ 00 -аар				
Жимобайлын 009 гарцаар _____ Үүрэн-руу төгссөн				
Жимобайлаас _____ Үүрэн-руу мессеж илгээсэн				
		<u>-д нийт төлөх</u> -		
_____ -оос-> Жимобайлруу	тариф	дуудлага	хугацаа /мин/	Төлбөр
Яриа				
_____ с Жимобайлын Үүрэн -руу				
_____ с Жимобайлын 009-р				
_____ ын 00 гарцаар Жимобайлын Үүрэн-рүү төгссөн				
_____ с Жимобайлын Үүрэн –руу мессеж илгээсэн				
		<u>Жимобайл-д нийт төлөх</u>		
Тооцоо нийлсэн				
_____ ыг төлөөлж:		инженер		
<u>Жимобайлыг төлөөлж:</u>		инженер		



Сүлжээ хоорондын харилцан холболтын
..... тоот гэрээний Хавсралт 5

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ
--- албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл**

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

Жимобайл ХХК-ийн албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

Хавсралт баталсан:

Талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, компанийн тэмдэг